

# Хүүхдэд зориулсан Библи танилцуулж байна



## Худаг дээрх ЭМЭГТЭЙ

Зохиогч: Edward Hughes

Зураглаач: Lazarus

Орчуулсан: Damdin Horolsuren

Найруулсан: Ruth Klassen

Түүх 47/60

[www.M1914.org](http://www.M1914.org)


*Bible for Children, PO Box 3, Winnipeg, MB R3C 2G1 Canada*

Зөвшөөрөл: Та энэ бүтээлийг хувилах хуулах эрхтэй харин худалдахыг хориглоно.

Монгол хэл


Mongolian

Есүс шавь нартайгаа Самари нутгаар явж байлаа.  
Тэгээд тэд Сухар нэртэй нэгэн хотод ирэв.




1

Тэнд нэгэн худаг байсан бөгөөд Сухар хотын хүмүүс  
энэ худгаас ундалдаг байв. Израилийн өвөг эцэг  
Иаков энэ худгыг ужжээ.



2

Үд дунд болж нар шарж маш халуун байлаа. Шавь нар нь Сухар хот уруу хүнс худалдан авахаар явсан хойгуур Есүс худгийн ойролцоо эргэн тойрныг харан сууж байв.



3


Есүс ганцаараа байлаа. Удалгүй Сухар хотод амьдардаг нэгэн эмэгтэй ус авахаар ирэв.



4


Есүс түүнд "Надад уух юм өгөөч" гэлээ.

Тэр эмэгтэй ихэд гайхжээ. "Та Иудей хүн байж Самари эмэгтэй надаас яахин уух юм асууна вэ?" хэмээн эмэгтэй хариулав. Тэр үед Иудейчууд Самари хүмүүстэй харьцдаггүй байв.




5

Тэр эмэгтэй Есүсийг "Хэрэв чи ус өгөөч хэмээн асууж байгаа хүн хэн гэдгийг мэдсэн бол би чамд амийн усыг өгөх байсан" гэхийг сонсоод бүр гайхсан байхаа.



6

Тэр эмэгтэй Есүст "Эзэн энэ худаг гүн танд ус утгах юм алга. Гэтэл та амийн усыг хаанаас авах вэ?" "Та бидний өвөг Иаковаас агуу гэж үү? Тэр энэ худгийг бидэнд өгсөн юм" гэв.




7

Есүс "Энэ уснаас уух хүн бүр дахин цангана" гээд "Харин өөрт нь Миний өгөх уснаас уугч хэн ч хэзээ ч цангахгүй.



8



Харин Миний өгөх ус тэр хүний дотор мөнх аминд хүртэл оргилох булаг болно" гэхэд эмэгтэй Түүнд "Эээн, тэр усаа надад өгөөч" гэв.


9



Есүс явж нөхрөө дуудаад ир гэж айлдав. Тэр эмэгтэй "Би нөхөргүй" гэв. Есүс "Чи таван нөхөртэй байсан бөгөөд одоо чамтай байгаа хүн ч нөхөр чинь биш" гэв.


10

Тэр эмэгтэй Есүсыг эш үзүүлэгч болохыг ойлгов. Тэр эмэгтэй Түүнтэй Бурханд хаана мөргөх вэ?




11

Иерусалемд уу эсвэл Самаричуудын ариун ууланд уу гэж маргав. Есүс үнэн мөргөгчид нь сүнсээрээ, үнэнээр Эцэгт минь мөргөдөг гэв.



12

Тэр эмэгтэй Есүст "Христ гэгч Мессиа ирэхийг би мэднэ. Тэр Нэгэн ирэхдээ бүх зүйлсийг бидэнд мэдүүлж өгнө" гэхэд Есүс түүнд "Чамтай ярьж байгаа Би бол Тэр мөн" гэв. Тэр үед шавь нар нь буцан ирэв. Тэгтэл өнөөх эмэгтэй усныхаа үнэт савыг худаг дээр орхин хот уруу явжээ.



13



Өнөөх эмэгтэй Сухар хот уруу ирж "Миний үйлдсэн бүхнийг надад хэлсэн хүнийг ирж үзэгтүн, Тэр Христ биш үү?" гэсэнд хүмүүс хотоос гарч Есүс уруу очиж байв.

14

Энэ үед шавь нар нь Есүсээс Багшаа авч ирсэн хоолноос зооглооч гэхэд Есүс "Миний хоол бол Намайг илгээсэн Түүний хүслийг үйлдэн, ажлыг нь гүйцэлдүүлэх явдал мөн" гэв.




15

Түүний хийх ёстой ажил нь хүмүүсийг Бурхан уруу авч ирэх явдал байв.




16

Өнөөх Самари эмэгтэйн хэлсэн үгийг сонсоод Самаричуудаас олон хүн Есүст итгэжээ. Тэд Есүсээ тэдэнтэй хамт байхыг гуйсанд Есүс тэнд хоёр хоног байжээ.



17

Олон хүн Есүсийн үгийг сонсоод итгэж байлаа. Тэд "Одоо бид өөрсдөө сонсоод энэ Нэгэн бол үнэхээр ертөнцийн Аврагч мөн гэдгийг мэдлээ" гэцгээж байв.



18

Худаг дээрх эмэгтэй  
Бурханы үг Библээс авсан түүх  
Иохан 4

"Таны үгсийн тунхаглал гэгээрүүлдэг."  
Дуулал 119:130

Бурхны гэм гэж нэрлэдэг муу зүйлийг бид хийдгийг Бурхан сайн мэднэ. Гэмийн шийтгэл нь үхэл юм.

Бурхан бидэнд маш их хайртай Тэрээр өөрийн хүү Есүсийг бидний гэмийн төлөөс болгон загалмайн үхэлд тушаасан. Есүс дахин амилж мөнхийн улсдаа буцсан! Одоо Бурхан бидний гэмийг уучилж чадна.

Хэрвээ та гэмээсээ эргэхийг хүсвэл, Бурханд хандан ийнхүү хэлээрэй: Бурхан минь ээ, Би Есүс миний төлөө үхээд дахин амилсан гэдэгт итгэж байна. Миний амьдралд орж ирээд миний гэмийг уучлаач тэгээд би шинэ амьдралаар амьдарч дараа нь тантай хамт мөнхөд амьдрах болно.  
Таны хүүхэд шиг Таны төлөө амьдрахад туслаач.  
Амен Иохан 3:16

Библи уншиж өдөр бүр Бурхантай ярилцаарай!